


"БЗӨБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
~~2024~~ оны ~~03~~ дугаар сарын ~~18~~-ны өдрийн
~~01/06~~ дугаар тушаалын ~~24~~ дугаар хавсралт



АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А.Ерөнхий зүйл

1.Байгууллагын нэр: "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компани	2.Нэгжийн нэр: Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс
3.Ажлын байр (Албан тушаал)-ын нэр Хэлтсийн ахлах, эдийн засагч (2631-11)	3.1.Албан тушаалын ангилал: АХ
4.Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1.Гүйцэтгэх захирал 2.Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга	
5.Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал: 1. Эдийн засагч 2. Борлуулалтын төлөвлөлт хариуцсан инженер 3.Засвар хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан инженер 4.Төсвийн инженер	

Б.Чиг үүрэг

Ажлын байрны зорилго	Компанийн өнөөгийн болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг хямдруулах, үр ашгийг дээшлүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах.
Ажлын байрны үндсэн чиг үүрэг.	
1.Компанийн жилийн болон хэтийн төлөвлөгөө боловсруулан компанийн санхүү эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг, зардлыг хэмнэх ажлыг зохион байгуулах. 2.Компанийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлд нь судалгаа шинжилгээ хийж, салбаруудын төлөвлөлтийг удирдлагаар хангаж, хянаж нэгтгэх. 3.Компанийн тухайн жилийн төлөвлөгөөт алдагдлыг бууруулж, орлогыг нэмэгдүүлэх, нийт орлого зарлагын сар бүрийн мэдээг хянаж, дүнг удирдлагуудад танилцуулж, холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэх. 4.Компанийн хэмжээнд шаардлагатай төсвийг хянаж ажиллах. 5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах. 6. Бусад үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлууд.	

Албан тушаалын үндсэн ажлын чиг үүрэг	
1.Ажлын байрны 1 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд: 1.1.Компанийн бизнес төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, судлах, боловсруулах, бэлтгэх ажлыг гүйцэтгэх; 1.2.Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус орлогын судалгааг гаргуулан захиалгыг авч хянаж нэгтгэн, төлөвлөгөөг боловсруулж, удирдлагад танилцуулах; 1.3.Компанийн үндсэн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын төлөвлөгөөг НББ-ийн хуулийн дагуу зардлын нэр төрөл тус бүрээр нарийвчлан авч судлан нэгтгэж, төлөвлөгөөг боловсруулж, удирдлагад танилцуулах;	

1.4.Компанийн тухайн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, бизнес төлөвлөгөө, зорилтот түвшний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, компанийн удирдлагад танилцуулж, ТУЗ, ЭХЯ, ТӨХ-нд хүргүүлж, хэлэлцүүлж батлуулах.

1.5.Хэлтсийн дарга, Хэлтсийн ахлах, эдийн засагч бие биенээ эзгүй байх үед орон ажиллах, хэлтсийн ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар хангаж, компанийн удирдлагаас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцож, өгсөн үүрэг даалгаврын биелэлт гүйцэтгэлийг тухай бүр гаргаж ажиллах;

1.6.Компанийн тухайн улирлын мөнгөний урсгалын тооцоонд дүн шинжилгээ хийж, ЭХЗХ-д хүргүүлэх;

2.Ажлын байрны 2 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

2.1.Компанийн тухайн жилийн үнэ, тариф (БОШХ)-г боловсруулж, ЭХЗХ-ны Зохицуулагчдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулан мөрдөж ажиллах;

2.2.Компанийн тухайн улирлын мөнгөний урсгалын тооцоог хийж, ЭХЗХ-д хүргүүлэх;

2.3.Батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшний үзүүлэлтийн төлөвлөгөө, орон тоо, цалингийн сангийн төлөвлөгөөг харьяа салбар тус бүрээр гаргаж, гүйцэтгэх захирлаар батлуулан хүргүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

2.4.Компанийн санхүү эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга замуудын талаар санал боловсруулан танилцуулж, батлуулан, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

2.5.Компанийн удирдлага болон холбогдох дээд шатны газруудад шаардлагатай төлөвлөгөө, тайлан, мэдээ, мэдээлэл, танилцуулга, тооцоо, судалгаа шинжилгээний баримт материалыг бэлтгэж, боловсруулж, хугацаанд нь хүргүүлэх;

3.Ажлын байрны 3 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

3.1.Компанийн тухайн сар, улирал, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтүүдийн биелэлтэд иж бүрэн дүн шинжилгээ хийж Захирлын зөвлөлийн болон ТУЗ-ийн хуралд танилцуулах;

3.2.Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн шагналын үзүүлэлтүүдийн биелэлтийг гаргаж, шагналын үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг ТУЗ-д танилцуулж батлуулах, батлагдсан шагналын санд багтаан компани, харьяа салбаруудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн шагналын үзүүлэлтүүдийн биелэлтийг гаргаж, компанийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан харьяа салбар, алба хэлтсүүдэд хүргүүлэх;

3.3.Компанийн алба, хэлтэс, харьяа салбаруудын Хангах, Түгээх үйл ажиллагаа хариуцсан ажиллагсдын сарын үйл ажиллагааны үр дүнгийн шагналын үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг сар бүрийн тайлан тэнцлийн дүн болон Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, Хангах үйл ажиллагааны бодлого хэрэгжилтийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтсүүдээс гаргуулан авч нэгтгэн сарын үр дүнгийн шагналын үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг компанийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан харьяа салбар, алба хэлтсүүдэд хүргүүлэх;

3.4.Харьяа салбар нэгжүүдээс ирүүлсэн мөнгөн хөрөнгийн хэрэгцээ, захиалгыг хүлээн авч, төлөвлөгөөний дагуу хянаж, санхүүжилтийн хурлаар хэлэлцэж захиалгыг батлах, компанийн мөнгөн урсгалын төлөвлөгөөг боловсруулах, удирдлагад танилцуулж батлуулан хяналт тавьж ажиллах.

4.Ажлын байрны 4 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:

4.1.Компанийн бодлогын дагуу хувьсах зардлыг нормын дагуу боловсруулах, нэгжүүдийн график, ажлын эзлэхүүн, гэрээ хэлцлийн үндсэн дээр тогтмол зардлын төлөвлөгөө боловсруулах;

4.2.Компанийн сар, улирал, жилийн тайлан тэнцлийг үндэслэн хэтэрсэн, хэмнэсэн зардал тус бүрд судалгаа, шинжилгээ хийж, цаашид зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.3.Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ТЗЭ компаниудын ажилтнуудын цалингийн жишиг, дундаж цалин болон амьжиргааны түвшний өсөлттэй уялдуулж, ажилтнуудын үндсэн ба тарифт цалинг нэмэгдүүлэх санал боловсруулан удирдлагад танилцуулж, ТУЗ-ийн шийдвэр гаргуулж, хэрэгжүүлж ажиллах;

5.Ажлын байрны 5 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

5.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах.

5.2.Галын аюулгүй байдлын хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах.

5.3.Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хангах, ХЭМАБ-ын аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хэрэгцээ шаардлагаа илэрхийлэх, зөвлөлдөх.

5.4.Ажил гүйцэтгэх үед учирч болзошгүй аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.5.Ажил эхлэхээс өмнө ажлын даалгавар, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг анхан шатны удирдах ажилтнаас бичгээр авах, ажил гүйцэтгэх тохиолдолд тухайлсан зааварчилгаа авах.

5.6.Гал унтраах багаж, хэрэглэлүүдийн байрлалыг мэддэг, шаардлагатай үед ашиглаж чаддаг байх.

5.7.Осол болон осолд дөхсөн тохиолдлын үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх.

5.8.Ажил гүйцэтгэхдээ анхаарал болгоомжтой ажиллах, бусдын анхаарлыг сарниулахгүй байх, ажилд хамааралгүй хүнийг ажлын байранд нэвтрүүлэхгүй байх.

5.9.Ажил дээр гарсан осол, гэмтлийг анхан шатны удирдлага ба яаралтай тусламжийн хэсэгт цаг тухайд нь яаралтай мэдээлэх.

5.10.Ажлын байранд илэрсэн аюулыг тухай бүр холбогдох албан тушаалтанд мэдээлэх, аюулыг арилгаж эрсдэлийг үнэлсний дараа ажлыг эхлүүлэх.

5.11.Өөрийн ажлын байр, орчин, тоног төхөөрөмжөөс үүдэн гарч болох эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг удирдах ажилтнуудтай хамтран зохион байгуулж, зөрчил илэрсэн тохиолдолд арилгуулах /арилгах/ арга хэмжээг авах.

5.12.Технологийн горим, тоноглолын ашиглалтын зааврыг чанд мөрдөж ажиллах.

5.13.Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.

5.14.Ажлын байрны анхан шатны үзлэг хийх, холбогдох хариу арга хэмжээг авах.

5.15.Гамшиг ослын үед, өөрийн чиг үүрэг, гал унтраах багаж хэрэгслийн байршил, аврах зам гарцыг мэддэг байх.

5.16.Өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд оруулах аливаа үйлдэл гаргахгүй байх

5.17.Шаардлагатай тохиолдолд аваар эсэргүүцэх дасгал, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, гал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх дасгал, өдөрлөгт биечлэн оролцох;

6.Ажлын байрны 6 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

6.1.Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон бусад дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах;

6.2.Удирдах албан тушаалтнууд, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хариуцсан ажил үүргийн хүрээнд үнэн бодит мэдээллээр хангах;

6.3.Захирлын зөвлөлийн хурал, шуурхай зөвлөгөөн, удирдлагаас хариуцсан чиг үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр зохион байгуулах, эргэн тайлагнах;

6.4.Жил бүрийн ээлжит болон ээлжит бус сургалтад бүрэн хамрагдах;

6.5.Ажлын шаардлагын дагуу компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар байнгын болон байнгын бус комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж батлагдсан журмын дагуу ажиллах;

6.6.Хариуцсан чиг үүргийн хүрээнд тайлан мэдээ, зөвлөмж, акт, дүгнэлт боловсруулах;

6.7.Ажлын төлөвлөгөөг сар, жилээр гарган харьяалах нэгжийн удирдлагаар батлуулан мөрдөж ажиллах, гүйцэтгэлийг гаргах;

6.8.Хагас болон бүтэн жилээр ажлын тайлан бичиж хамгаалах;

6.9.Хариуцсан чиг үүргийн хүрээнд компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах.

6.10.Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;

6.11.Ёс зүйн зөрчилгүй ажиллах

6.12.Өөрийн хариуцсан эд хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

- 6.13.Хариуцсан чиг үүргийн хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журам, стандартын дагуу баримт бичиг зохиох, хөтлөх, төлөвлөх;
- 6.14.Архивын баримтыг ХХНЖ-ийн дагуу бүрдүүлж, хууль, журамд заасан хугацаанд архивд хүлээлгэн өгөх;
- 6.15.Иргэд, байгууллага, ажилчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- 6.16.Байгууллагаас албан ёсоор зохион байгуулж буй олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
- 6.17.Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;
- 6.18.Ажлын зайлшгүй шаардлагаар Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллах.

В.Тавигдах шаардлага:

1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Шаардлага
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
		Мэргэжил	- Эдийн засаг-0311; - Нягтлан бодох бүртгэл, татвар-0411.
		Мэргэшил	
		Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх.
		Ур чадвар	- Санхүүгийн программууд дээр ажиллах; - албан ажлын хэрэгцээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, судалж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - харилцааны соёл, нээлттэй харилцаа бий болгох чадвартай; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - ёс зүйтэй байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах.
	1.2.Бусад шаардлага	Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны онцлогийг мэддэг байх.	

Г.Хүчин зүйлс:

1.Ажлын байрны харилцаа холбоо	1.1.Байгууллагын дотоод орчинд	- Гүйцэтгэх захирал; - Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга; - Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч; - Бусад алба хэлтсийн дарга, инженерүүд; - Салбарын удирдлага, санхүүгийн ажилтнууд.
	1.2.Байгууллагын гадаад орчинд	- ЭХЯ; - Сангийн яам; - ТӨБЗГ; - ЭХЗХ; - ЭХҮТ; - ЭХЭЗХ; - ДҮТ ТӨХХК; - ТЕГ; - СЗХ; - ҮАГ; - Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд; - Иргэн, хуулийн этгээд.
2.Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	2.1.Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хариуцлага хүлээнэ. Мөн ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд, хөдөлмөрийн гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.	
3.Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн	Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан албан тушаалын үндсэн цалин, бусад хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон сар болон жилийн үйл ажиллагааны урамшуулал, удаан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, хөдөлмөрийн болон хамтын гэрээнд заасан урамшуулал, нэмэгдэл хөлс, нэмэгдлүүд, хоол унааны хөнгөлөлт
	3.2.Материалын	Өмч, хөрөнгө эзэмшигчийн картаар хүлээн авсан эд хөрөнгө
	3.3.Хүний	
	3.4.Бусад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр
4.Ажлын байрны нөхцөл	4.1.Хөдөлмөрийн нөхцөл	Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана.

Д.Баталгаажуулалт:

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан
Албан тушаалын нэр Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга(Я.Отгонзул)	Албан тушаалын нэр: - Гүйцэтгэх захирал(Х.Ганчулуун)
ЗХНХ-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн(М.Нарантуяа)	(Гарын үсэг)
20.... оны..... сарын.....өдөр	20.... оны..... сарын.....өдөр

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
 02.06.2023 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
 01/96 дугаар тушаалын 2.2 дугаар хавсралт

АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А.Ерөнхий зүйл

1.Байгууллагын нэр: “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компани	2.Нэгжийн нэр: Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс
3.Ажлын байр (Албан тушаал)-ын нэр Эдийн засагч (2631-11)	3.1.Албан тушаалын ангилал: АХ 3.2.Аюулгүй ажиллагааны групп:
4.Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1.Гүйцэтгэх захирал 2.Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга 3.Хэлтсийн ахлах, Эдийн засагч	
5.Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал:	

Б.Чиг үүрэг

Ажлын байрны зорилго	Компанийн өнөөгийн болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг хямдруулах, үр ашгийг дээшлүүлэх, цалин хөлсний оновчтой систем, механизм бүрдүүлэх, хяналт тавих, сар улирлын мэдээ тайлан гаргах, дүн шинжилгээ хийх, шилэн дансны тухай хуулийн дагуу нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь байршуулах.
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
1.Компанийн тухайн жилийн болон хэтийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, компанийн алба, хэлтэс, харьяа салбаруудын санхүү эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өртөг, зардлыг хэмнэх ажлыг зохион байгуулах;	
2.Харьяа салбарууд болон компанийн хэлтэс, албадын санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлд нь судалгаа шинжилгээ хийж, салбаруудын төлөвлөлтийг хянаж нэгтгэн харьяа салбаруудын тухайн жилийн төлөвлөгөөт алдагдлыг бууруулж, орлогыг нэмэгдүүлэх;	
3.Харьяа салбаруудын цахилгаан эрчим хүчний борлуулалтын мэдээ, шатахууны мэдээ болон бусад шаардлагатай мэдээ тайланг сар бүр нэгтгэн гаргаж, ахлах эдийн засагчаар хянуулан холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэх;	
4.Цалин хөлсний оновчтой бодлого боловсруулах, төлөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангах;	
5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах.	
6.Бусад үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлууд.	

Албан тушаалын үндсэн ажлын чиг үүрэг

1. Ажлын байрны 1 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:

1.1. Компани, харьяа салбаруудын бизнес төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, судлах, боловсруулах, бэлтгэх ажлыг гүйцэтгэх;

1.2. Компанийн алба, хэлтэс, харьяа салбаруудаас тухайн жилийн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус орлогын судалгааг гаргуулан захиалгыг авч нэгтгэн, төлөвлөгөөг боловсруулж, удирдлагад танилцуулах;

1.3. Компанийн алба, хэлтэс, харьяа салбаруудаас үндсэн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын төлөвлөгөөг НББ-ийн хуулийн дагуу зардлын нэр төрөл тус бүрээр нарийвчлан авч судлан нэгтгэж, төлөвлөгөөг боловсруулж, удирдлагад танилцуулах;

1.4. Батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшний үзүүлэлтийн биелэлтийг харьяа салбар тус бүрээр гаргаж, ахлах эдийн засагчид танилцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

2. Ажлын байрны 2 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

2.1. Компанийн удирдлага болон холбогдох газруудад шаардлагатай төлөвлөгөө, тайлан, мэдээ, мэдээлэл, танилцуулга, тооцоо, судалгаа шинжилгээний баримт материалыг бэлтгэж, боловсруулж, хянуулах;

2.2. Салбар, алба, хэсэг нэгжийн дотоод тооцооны төлөвлөгөөний биелэлтийг хянаж, гүйцэтгэлийг сар бүр гаргах;

2.3. Компанийн алба, хэлтэс, харьяа салбаруудын эдийн засгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг сар бүрийн тайлан тэнцлийг үндэслэн гаргаж, хянуулах;

2.4. Салбаруудын сар, улирал, жилийн эцсийн тайлан, тэнцэлд судалгаа, шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний ажлын төлөвлөгөө боловсруулах;

2.5. Салбар, алба, хэсэг нэгжийн сар, улирал, жилийн тайлан тэнцлийг үндэслэн хэтэрсэн, хэмнэсэн зардал тус бүрд судалгаа, шинжилгээ хийж, дүнг ахлах эдийн засагчид танилцуулж, хянуулах;

2.6. Шилэн дансны тухай хууль болон шил ажиллагааны хүрээнд холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд гаргаж байршуулах;

3. Ажлын байрны 3 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

3.1. Салбаруудын тухайн сарын Цахилгаан эрчим хүчний худалдан авалт, борлуулалтын бичилт, түгээлтийн алдагдлын тооцоо, цахилгаан эрчим хүчний хаалтын тооцоог ХҮАХБХ-с гаргуулан авч, мэдээг нэгтгэж гаргах;

3.2. Харьяа салбаруудын цахилгаан эрчим хүчний борлуулалтын бичилт, авлага цуглуулалтын гүйцэтгэлийг салбаруудын Хангах үйл ажиллагаа харриуцсан менежер, ахлах ня-бо, эдийн засагч, борлуулалтын ня-бо нараас сар бүрийн 3-ны дотор авч нэгтгэж гаргах;

3.3. Компанийн борлуулалтын мэдээг нэгтгэн гаргаж, хянуулан удирдлагад танилцуулж, ЭХЯ, ЭХЗХ-нд сар бүрийн 3-ны дотор хүргүүлэх;

3.4. Жилийн үйл ажиллагааны статистик мэдээг дараа оны 1 сарын 20-ны дотор, хөрөнгө оруулалтын мэдээг дараа улирлын 20-ны дотор, Борлуулалтын мэдээг дараа сарын 5-ны дотор гаргаж тус тус цахимаар хүргүүлэх.

3.5. Компани, харьяа салбаруудын шатахууны гүйцэтгэлийг салбаруудын эдийн засагч нараас сар бүрийн 10-ны дотор авч нэгтгэж гаргах, хэтрэлт хэмнэлтийн дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангах;

3.6. Эдийн засагч нар бие биенээ эзгүй байх үед орлон ажиллах;

4. Ажлын байрны 4 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

4.1. Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг ТЗЭ компаниудын ажилтнуудын цалингийн жишиг, дундаж цалин болон амьжиргааны түвшний өсөлттэй уялдуулж, ажилтнуудын үндсэн ба тарифт цалинг нэмэгдүүлэх тооцоо, судалгааг хийж, санал боловсруулан удирдлагад танилцуулах;

4.2. Компанийн цалин хөлсний зардлын төлөвлөгөөг компани салбар бүрээр сар, улирал, жилээр нэгтгэн боловсруулж компанийн бизнес төлөвлөгөөнд тусгах;

4.3.Компанийн орон тоо, албан тушаалын үндсэн цалингийн сүлжээ, ажилчдын тарифт цалингийн жишгийг тогтоож, батлуулах, мөрдүүлэх, биелэлтэнд хяналт тавих;

4.4.Компанийн хэмжээнд мөрдөгдөх цалин, шагнал, урамшууллын ажрмыг боловсруулах, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.5.Тодорхой судалгаа шинжилгээ дүгнэлтэнд тулгуурлан цалин, шагнал, урамшууллын журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, сайжруулах;

4.7.Сар бүр болон өссөн дүнгээр цалингийн мэдээг хугацаанд нь гаргаж төлөвлөгөөтэй харьцуулсан үр дүнг удирдлагуудад танилцуулах

5.Ажлын байрны 5 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:

5.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах.

5.2.Галын аюулгүй байдлын хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах.

5.3.Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хангах, ХЭМАБ-ын аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хэрэгцээ шаардлагаа илэрхийлэх, зөвлөлдөх.

5.4.Ажил гүйцэтгэх үед учирч болзошгүй аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.5.Ажил эхлэхээс өмнө ажлын даалгавар, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг анхан шатны удирдах ажилтнаас бичгээр авах, ажил гүйцэтгэх тохиолдолд тухайлсан зааварчилгаа авах.

5.6.Гал унтраах багаж, хэрэглэлүүдийн байрлалыг мэддэг, шаардлагатай үед ашиглаж чаддаг байх.

5.7.Осол болон осолд дөхсөн тохиолдлын үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх.

5.8.Ажил гүйцэтгэхдээ анхаарал болгоомжтой ажиллах, бусдын анхаарлыг сарниулахгүй байх, ажилд хамааралгүй хүнийг ажлын байранд нэвтрүүлэхгүй байх.

5.9.Ажил дээр гарсан осол, гэмтлийг анхан шатны удирдлага ба яаралтай тусламжийн хэсэгт цаг тухайд нь яаралтай мэдээлэх.

5.10.Ажлын байранд илэрсэн аюулыг тухай бүр холбогдох албан тушаалтанд мэдээлэх, аюулыг арилгаж эрсдэлийг үнэлсний дараа ажлыг эхлүүлэх.

5.11.Өөрийн ажлын байр, орчин, тоног төхөөрөмжөөс үүдэн гарч болох эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг удирдах ажилтнуудтай хамтран зохион байгуулж, зөрчил илэрсэн тохиолдолд арилгуулах /арилгах/ арга хэмжээг авах.

5.12.Технологийн горим, тоноглолын ашиглалтын зааврыг чанд мөрдөж ажиллах.

5.13.Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.

5.14.Ажлын байрны анхан шатны үзлэг хийх, холбогдох хариу арга хэмжээг авах.

5.15.Гамшиг ослын үед, өөрийн чиг үүрэг, гал унтраах багаж хэрэгслийн байршил, аврах зам гарцыг мэддэг байх.

5.16.Өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд оруулах аливаа үйлдэл гаргахгүй байх

5.17.Шаардлагатай тохиолдолд аваар эсэргүүцэх дасгал, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, гал, гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх дасгал, өдөрлөгт биечлэн оролцох;

6.Ажлын байрны 6 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

6.1.Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон бусад дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах;

6.2.Удирдах албан тушаалтнууд, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хариуцсан ажил үүргийн хүрээнд үнэн бодит мэдээллээр хангах;

6.3.Удирдлагаас хариуцсан чиг үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр зохион байгуулах, эргэн тайлагнах;

6.4.Жил бүрийн ээлжит болон ээлжит бус сургалтад бүрэн хамрагдах;

6.5.Ажлын шаардлагын дагуу компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар байнгын болон байнгын бус комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж батлагдсан журмын дагуу ажиллах;

6.6.Хариуцсан чиг үүргийн хүрээнд тайлан мэдээ, зөвлөмж, акт, дүгнэлт боловсруулах;

- 6.7.Ажлын төлөвлөгөөг сар, жилээр гарган харьяалах нэгжийн удирдлагаар батлуулан мөрдөж ажиллах, гүйцэтгэлийг гаргах;
- 6.8.Хагас болон бүтэн жилээр ажлын тайлан бичиж хамгаалах;
- 6.9.Хариуцсан чиг үүргийн хүрээнд компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах.
- 6.10.Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;
- 6.11.Ёс зүйн зөрчилгүй ажиллах
- 6.12.Өөрийн хариуцсан эд хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- 6.13.Хариуцсан чиг үүргийн хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журам, стандартын дагуу баримт бичиг зохиох, хөтлөх, төлөвлөх;
- 6.14.Архивын баримтыг ХХНЖ-ийн дагуу бүрдүүлж, хууль, журамд заасан хугацаанд архивад хүлээлгэн өгөх;
- 6.15.Иргэд, байгууллага, ажилчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- 6.16.Байгууллагаас албан ёсоор зохион байгуулж буй олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
- 6.17.Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;
- 6.18.Ажлын зайлшгүй шаардлагаар Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллах.

В.Тавигдах шаардлага:

		Үзүүлэлт	Шаардлага
			Боловсрол
1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
		Мэргэжил	- Эдийн засаг-0311; - Нягтлан бодох бүртгэл-0411. - Инженер-эдийн засагч
		Мэргэшил	
		Туршлага	-Тухайн мэргэжлээр салбарт 1-с дээш жил ажилласан;
		Ур чадвар	- Санхүүгийн программууд дээр ажиллах; - албан ажлын хэрэгцээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, судалж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - харилцааны соёл, нээлттэй харилцаа бий болгох чадвартай; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - ёс зүйтэй байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах.
	1.2.Бусад шаардлага		Эрчим хүчний салбарын үйл ажиллагааны онцлогийг мэддэг байх.

Г.Хүчин зүйлс:

1.Ажлын байрны харилцаа холбоо	1.1.Байгууллагын дотоод орчинд	- Гүйцэтгэх захирал; - Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга; - Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч; - Бусад алба хэлтсийн дарга, инженерүүд; - Салбарн удирдлага, санхүүгийн ажилтнууд.
	1.2.Байгууллагын гадаад орчинд	- ЭХЯ; - Сангийн яам; - ТӨБЗГ; - ЭХЗХ; - ЭХҮТ; - ЭХЭЗХ; - ДҮТ ТӨХХК; - ТЕГ; - СЗХ; - ҮАГ; - Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд; - Иргэн, хуулийн этгээд.
2.Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	2.1.Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хариуцлага хүлээнэ. Мөн ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд, хөдөлмөрийн гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.	
3.Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1.Санхүүгийн	Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан албан тушаалын үндсэн цалин, бусад хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон сар болон жилийн үйл ажиллагааны урамшуулал, удаан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, хөдөлмөрийн болон хамтын гэрээнд заасан урамшуулал, нэмэгдэл хөлс, нэмэгдлүүд, хоол унааны хөнгөлөлт
	3.2.Материалын	Өмч, хөрөнгө эзэмшигчийн картаар хүлээн авсан эд хөрөнгө
	3.3.Хүний	
	3.4.Бусад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр
4.Ажлын байрны нөхцөл	4.1.Хөдөлмөрийн нөхцөл	Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана.

Д.Баталгаажуулалт:

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан
Албан тушаалын нэр Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга (Я.Отгонзул) ЗХНХ-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн (М.Нарантуяа)	Албан тушаалын нэр Гүйцэтгэх захирал (Х.Ганчулуун) (Гарын үсэг)
20.... оны..... сарын.....өдөр	20.... оны..... сарын.....өдөр

"БЗӨБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2026 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн
А/96 дугаар тушаалын 23 дугаар хавсралт



АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А.Ерөнхий зүйл

1.Байгууллагын нэр: "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компани	2. Нэгжийн нэр: Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс
3.Ажлын байр (Албан тушаал)-ын нэр Борлуулалтын төлөвлөлт хариуцсан инженер (2151-11)	3.1.Албан тушаалын ангилал: ИТА
4.Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1.Гүйцэтгэх захирал 2.Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга 3. Хэлтсийн ахлах, Эдийн засагч	
5. Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалтны нэр:	

Б.Чиг үүрэг

Ажлын байрны зорилго	Компанийн хэмжээнд Хангах үйл ажиллагаанд баримталж буй бодлогын хүрээнд хүлээн авах цахилгаан эрчим хүчний хэмжээ, түгээлтийн алдагдал, борлуулах цахилгаан эрчим хүчний хэмжээг төлөвлөх, үр ашигтай ажиллах тооцооллыг хийх гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах, дүн шинжилгээ хийх, борлуулалтын хэмжээг өсгөх, алдагдлыг бууруулах чиглэлээр төлөвлөлтийг хийх, удирдлагыг мэдээллээр хангах;
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
1.Компанийн хэмжээнд хүлээн авах цахилгаан эрчим хүч, борлуулах цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтцийг төлөвлөх, дүн шинжилгээ хийж салбаруудын тухайн сар, улирал, жилийн худалдан авах цахилгаан эрчим хүч, борлуулалтын үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж, жилийн төлөвлөгөө гаргаж, томоохон хэрэглэгчийн хэрэглээний захиалга болон гүйцэтгэлд хяналт тавих, дүн шинжилгээ хийх;	
2.Цахилгаан эрчим хүчний хэрэглээний балансын тооцоог сар бүр хийж, хэрэглээний өсөлт, бууралтад хяналт тавьж судалгаа, дүгнэлт гаргах, удирдлагад танилцуулах;	
3.Цахилгаан эрчим хүчний алдагдлын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж ЭХЗХ-оор батлуулах, зорилтот түвшний үзүүлэлтийг гаргах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийж ажиллах ;	
4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах.	
5.Бусад үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлууд	
Ажлын байранд хийгдэх ажлууд	
1.Ажлын байрны 1 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:	
1.1.Компанийн цахилгаан эрчим хүч худалдан авалт, түгээлтийн алдагдлын төлөвлөгөөг сар, улиралд, хагас жил, бүтэн жилээр тооцож, дүгнэлт гарган, жилийн	

худалдан авах цахилгаан эрчим хүч, түгээлтийн алдагдлын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж ажиллах;

1.2. Батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшний үзүүлэлтийн биелэлтийг харьяа салбар тус бүрээр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

1.3. Компанийн удирдлага болон холбогдох газруудад шаардлагатай төлөвлөгөө, тайлан, мэдээ, мэдээлэл, танилцуулга, тооцоо, судалгаа шинжилгээний баримт материалыг бэлтгэж, боловсруулж хянуулах;

1.4. Салбаруудын холбогдох ИТА, ажилтнуудад эдийн засгийн төлөвлөлтийн талаар хичээл заах, зааварчилгаа өгөх, удирдан зохион байгуулах;

1.5. Сар бүр томоохон хэрэглэгчдийн хэрэглээний захиалга, төлөвлөлт гүйцэтгэлийг харьцуулж, дүн шинжилгээ хийх;

1.6. Хэрэглээний балансын төлөвлөгөөг нэгдсэн сүлжээ, импорт, тархмал эс үүсвэр зэрэг ХАЦЭХ-ний эх үүсвэр тус бүрээр нь сараар, жилээр салбараар, нэгтгэлээр гаргаж удирдлагуудад танилцуулан батлуулах, батлагдсан төлөвлөгөөг харьяалах дээд шатны газруудад хугацаанд нь хүргүүлэх;

1.7. Засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан инженер, Борлуулалтын төлөвлөлт хариуцсан инженер бие биеэ эзгүй байх үед орон ажиллах;

2. Ажлын байрны 2 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд

2.1. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний балансын тооцоог сараар болон өссөн дүнгээр, салбар бүрээр гаргаж, хэрэглээний өсөлт, бууралтын судалгаа, нөлөөлсөн хүчин зүйлийн талаар дүгнэлт гаргах, удирдлагад танилцуулах;

2.2. Хэрэглээний балансыг нэгдсэн сүлжээ, импорт, тархмал эс үүсвэрээс ХАЦЭХ-ний эх үүсвэр тус бүрээр гүйцэтгэлийг гаргаж төлөвлөгөөтэй харьцуулсан дүн шинжилгээг хийж, дүгнэлт гарган удирдлагуудад танилцуулах;

3. Ажлын байрны 3 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

3.1. Техникийн алдагдал, арилжааны алдагдлын судалгааг гаргах, өссөн буурсан тайлбар гаргах;

3.2. Жилийн эцсийн шинийн болон шинийн бус түгээлтийн алдагдлын хэмжээг боловсруулах, жил бүрийн төлөвлөлтийг гаргах;

3.3. Компанийн хэмжээнд түгээлтийн алдагдлын хувь хэмжээг Эрчим хүчний зохицуулах хороонд тайлагнах батлуулах;

3.4. Сар бүрийн түгээлтийн алдагдлыг гүйцэтгэлийг Эрчим хүчний зохицуулах хорооны сайтад бүртгэх;

3.5. Сар бүр томоохон хэрэглэгчдийн хэрэглээний захиалгыг нэгтгэн авч гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;

3.6. Хэрэглээний бүтэц, салбаруудын тухайн сар, улирал, жилийн худалдан авах цахилгаан эрчим хүч борлуулалтын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх;

4. Ажлын байрны 6 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах.

6.2. Галын аюулгүй байдлын хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах.

6.3. Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хангах, ХЭМАБ-ын аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хэрэгцээ шаардлагаа илэрхийлэх, зөвлөлдөх.

6.4. Ажил гүйцэтгэх үед учирч болзошгүй аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд заагдсан эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх.

6.5.Ажил эхлэхээс өмнө ажлын даалгавар, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг анхан шатны удирдах ажилтнаас бичгээр авах, ажил гүйцэтгэх тохиолдолд тухайлсан зааварчилгаа авах.

6.6.Гал унтраах багаж, хэрэглэлүүдийн байрлалыг мэддэг, шаардлагатай үед ашиглаж чаддаг байх.

6.7.Осол болон осолд дөхсөн тохиолдлын үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх.

6.8.Ажил гүйцэтгэхдээ анхаарал болгоомжтой ажиллах, бусдын анхаарлыг сарниулахгүй байх, ажилд хамааралгүй хүнийг ажлын байранд нэвтрүүлэхгүй байх.

6.9.Ажил дээр гарсан осол, гэмтлийг анхан шатны удирдлага ба яаралтай тусламжийн хэсэгт цаг тухайд нь яаралтай мэдээлэх.

6.10.Ажлын байранд илэрсэн аюулыг тухай бүр холбогдох албан тушаалтанд мэдээлэх, аюулыг арилгаж эрсдэлийг үнэлсний дараа ажлыг эхлүүлэх.

6.11.Өөрийн ажлын байр, орчин, тоног төхөөрөмжөөс үүдэн гарч болох эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг удирдах ажилтнуудтай хамтран зохион байгуулж, зөрчил илэрсэн тохиолдолд арилгуулах /арилгах/ арга хэмжээг авах.

6.12.Технологийн горим, тоноглолын ашиглалтын зааврыг чанд мөрдөж ажиллах.

6.13.Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.

6.14.Ажлын байрны анхан шатны үзлэг хийх, холбогдох хариу арга хэмжээг авах.

6.15.Гамшиг ослын үед, өөрийн чиг үүрэг, гал унтраах багаж хэрэгслийн байршил, аврах зам гарцыг мэддэг байх.

6.16.Өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд оруулах аливаа үйлдэл гаргахгүй байх

6.17.Шаардлагатай тохиолдолд аваар эсэргүүцэх дасгал, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, гал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх дасгал, өдөрлөгт биечлэн оролцох;

5.Ажлын байрны 7 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

7.1.Харьяалах нэгжийн удирдлагын ажил үүргийг шалгах, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих;

7.2.Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон бусад дүрэм журам, стандартыг мөрдөж ажиллах;

7.3.Удирдлага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хариуцсан ажил үүргийн хүрээнд үнэн бодит мэдээллээр хангах;

7.4.Удирдлагаас хариуцсан чиг үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр зохион байгуулах, эргэн тайлагнах;

7.5.Жил бүр ээлжит болон ээлжит бус мэргэжлийн сургалтад бүрэн хамрагдах;

7.6.Ажлын шаардлагын дагуу компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар байнгын болон байнгын бус ажиллагаатай комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж батлагдсан журмын дагуу ажиллах;

7.7.Хариуцсан чиг үүргийн хүрээнд тайлан мэдээ, зөвлөмж, акт, дүгнэлт боловсруулах;

7.8.Ажлын төлөвлөгөөг сар, жилээр гарган гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөж ажиллах, гүйцэтгэлийг гаргах;

7.9.Хагас болон бүтэн жилээр ажлын тайлан бичиж хамгаалах;

7.10.Өөрийн хариуцсан эд хөрөнгө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

7.11.Хариуцсан чиг үүргийн хүрээнд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрэм журам, стандартын дагуу баримт бичиг зохиох, хөтлөх, төлөвлөх;

7.12.Иргэд, байгууллага, ажилчдаас хариуцсан чиг үүргийн хүрээнд ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

7.13.Байгууллагаас албан ёсоор зохион байгуулж буй олон нийтийн үйл ажиллагаанд оролцох;

7.14.Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;

7.15.Ажлын зайлшгүй шаардлагаар Хөдөлмөрийн тухай хууль, компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллах.

В.Тавигдах шаардлага:



1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Шаардлага
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
		Мэргэжил	- Цахилгаан системийн автоматжуулалт-071304; - Цахилгааны инженер-071309 - Цахилгаан хангамж-071310 - Цахилгаан систем
		Мэргэшил	
		Туршлага	Мэргэжилээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх.
		Ур чадвар	- Удирдан зохион байгуулах - албан ажлын хэрэгцээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, судалж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - ёс зүйтэй байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох; - албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - байгууллага, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах.

Г.Хүчин зүйлс:

	1.1.Байгууллагын дотоод орчинд	- Гүйцэтгэх захирал; - Ерөнхий инженер; - Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга; - Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч;
--	--------------------------------	--

1. Ажлын байрны харилцаа холбоо		- Компанийн хэлтэс, албаны дарга, ажилтнууд; - Салбарын удирдлага, ажилтнууд.
	1.2. Байгууллагын гадаад орчинд	- ЭХЯ; - ЭХЗХ; - ЭХҮТ; - ЭХЭЗХ; - ТӨБЗГ - Хэвлэл мэдээллийн байгууллагууд; - Бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд; - Иргэн, хуулийн этгээд.
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	2.1. Хөдөлмөрийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн болон эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хариуцлага хүлээнэ. Мөн ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хүрээнд, хөдөлмөрийн гэрээний дагуу хариуцлага хүлээнэ.	
3. Ажлын байрны нөөц хэрэгсэл	3.1. Санхүүгийн	Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан албан тушаалын үндсэн цалин, бусад хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон сар болон жилийн үйл ажиллагааны урамшуулал, эрчим хүчний салбарт ажилласан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, хөдөлмөрийн болон хамтын гэрээнд заасан урамшуулал, нэмэгдэл хөлс, нэмэгдлүүд, хоол унааны хөнгөлөлт
	3.2. Материалын	Өмч, хөрөнгө эзэмшигчийн картаар хүлээн авсан эд хөрөнгө
	3.3. Хүний	Харьяалагдах хэлтсийн дарга, ажилтнууд
	3.4. Бусад	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр
4. Ажлын байрны нөхцөл	4.1. Хөдөлмөрийн нөхцөл	Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллана.

Д. Баталгаажуулалт:

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан:	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан:
ЗХНХ-ийн дарга  (Я.Отгонзул)	Гүйцэтгэх захирал  (Х.Ганчулуун)
ЗХНХ-ийн Хүний нөөцийн мэргэжилтэн  (М.Нарантуяа)	
20.... оны..... сарын.....өдөр	20.... оны..... сарын.....өдөр

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
~~2021~~ оны 03 дүгээр сарын 12-ны өдрийн
 1/96 дугаар тушаалын 24 дугаар хавсралт



АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А.Ерөнхий зүйл

1.Байгууллагын нэр: "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компани	2. Нэгжийн нэр:Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс
3.Ажлын байр (Албан тушаал)-ын нэр Засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан инженер (2151-11)	3.1.Албан тушаалын ангилал: ИТА
4.Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: 1.Гүйцэтгэх захирал 2.Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга 3.Хэлтсийн ахлах, Эдийн засагч	
5. Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалтны нэр:	

Б.Чиг үүрэг

Ажлын байрны зорилго	Компанийн жил бүрийн засварын ажил, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эдийн засгийн үр ашгийг үнэлэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх талаар судалгаа шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх, мөн компанийн хэмжээнд шаардлагатай бараа материалын худалдан авалтын судалгааг гаргаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хуулийн дагуу төлөвлөх, боловсруулах, батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах;
Ажлын байрны үндсэн чиг үүрэг	
1.Компанийн хэмжээний их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, цахилгаан тоног төхөөрөмж, барилга байгууламж, машин механизмд хийгдэж урсгал засварын ажлын төлөвлөлтийн гаргаж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ өгөх 2.Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдалд бэлэн байх аюулгүй нөөцийн материалыг төлөвлөх, хөрөнгийг шийдвэрлүүлэх 3.Түгээх сүлжээнд техник, технологийн шинэчлэл хийх, хүчин чадлаа нэмэгдүүлэх, одоогийн болон өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, чанартай, хүртээмжтэйгээр хангах, үр ашигтай ажиллах төлөвлөлтийг хийж, компанийн дунд ба урт хугацаанд төлөвлөгдсөн техникийн шинэчлэлт, төсөл хөтөлбөрүүдийн судалгаа гаргах, батлуулах; 4.Компанийн худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих, шаардлагатай өөрчлөлтийг хуульд нийцүүлэн төлөвлөн боловсруулах, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд тодотгол оруулах, гүйцэтгэх удирдлагын түвшинд танилцуулж, батлуулах; 5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллах. 6.Бусад үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлууд.	

Ажлын байранд хийгдэх ажлууд

1. Ажлын байрны 1 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:

1.1. Компанийн цахилгаан тоноглол, дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, цахилгаан дамжуулах кабель шугамуудын шинэчлэлийн ажлын төлөвлөгөөний саналыг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн гаргах;

1.2. Компанийн их засварын ажлыг тоноглолын олон жилийн график төлөвлөгөөний дагуу техник тоног төхөөрөмжийн элэгдэл, үзлэгээр илэрсэн гэмтэл, тухайн тоноглолд гарсан тасралтын тоо, тасарсан шалтгаан, засварын ажлын давтамж, туршилт хэмжилтийн дүнг үндэслэн төлөвлөх;

1.3. Компанийн цахилгаан тоног төхөөрөмж, барилга байгууламж, машин механизмд хийгдэх урсгал засварын ажлын төлөвлөлтийг гаргаж батлуулах;

1.4. Компанийн их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нэгтгэн гаргах, хэлтсийн даргад танилцуулан захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, холбогдох дээд шатны удирдлагаар батлуулах, гүйцэтгэлийг хянах, явцын болон жилийн эцсийн тайланг удирдлагуудад тайлагнах;

1.5. Компанийн нэгж, салбаруудаас шаардлагатай бараа материал, сэлбэгийн захиалгыг авч компанийн хэмжээнд нэгтгэх;

1.6. Нэгжүүдээс ирсэн бараа материалын захиалгыг хянан боловсруулалт хийж, агуулахын үлдэгдэл, дотоод нөөц, худалдан авах, ажиллагааны хэрэгцээг тодорхойлж, худалдан авах ажиллагааны бүлэглэл, багцлалыг хийж, компанийн худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийг хийх, Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах, батлуулах;

1.7. Компанийн худалдан авалт хариуцсан албаны оруулсан гүйцэтгэлд хяналт тавих, худалдан авалтын гүйцэтгэлийн нэгтгэл гарах;

1.8. Засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан инженер, Борлуулалтын төлөвлөлт хариуцсан инженер бие биеэ эзгүй байх үед орлон ажиллах;

2. Ажлын байрны 2 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд

2.1. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдалд бэлэн байх аюулгүй нөөцийн материалыг эрчим хүчний системийн болон компанийн батлагдсан дүрэм, журмын дагуу төлөвлөх, хариуцсан нэгжийн удирдлагад танилцуулах, батлуулах;

2.2. Компанийн үйлчлэх хүрээнд чадлын дутагдал үүсэж, өсөн нэмэгдэх хэрэглээг хангахгүй болсон нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай техникийн арга хэмжээ авах төлөвлөлтийг хийх;

2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон сум орон нутгийн хөрөнгө оруулалтад бүс нутгийн чанартай цахилгаан хангамжийн чанарыг дээшлүүлэх, чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх, орон нутгийн удирдлагад санал оруулах, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж төлөвлөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

3. Ажлын байрны 3 дугаар үндсэн чиг үүргийн хүрээнд:

3.1. Компанийн үйлчлэх хүрээнд өсөн нэмэгдэж байгаа хэрэглээтэй уялдуулан техникийн шинэчлэл хийх шаардлагатай ажлуудыг 5 жилийн хугацаатай (*дунд хугацааны төлөвлөгөө*) төлөвлөж төлөвлөгөөг батлуулах;

3.2. Компанийн үйлчлэх хүрээнд өсөн нэмэгдэж байгаа хэрэглээтэй уялдуулан техникийн шинэчлэл хийх шаардлагатай ажлуудыг 10 жилийн хугацаатай (*урт хугацааны төлөвлөгөө*) төлөвлөж төлөвлөгөөг батлуулах;

3.3. Компанийн хэмжээнд шаардлагатай бараа материалын худалдан авалтын судалгааг гаргаж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуульд нийцүүлэн төлөвлөх, боловсруулах, батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах;

4. Ажлын байрны 4 дүгээр үндсэн чиг үүргийн хүрээнд:

4.1. Компанийн хэмжээнд амжилтгүй болсон тендерийн судалгааг гаргаж шалтгааныг судлах, шаардлагатай тохиолдолд хуульд нийцүүлэн өөрчлөлт хийх саналыг хариуцсан удирдлагуудад танилцуулан арга хэмжээ авч ажиллах;

4.2. Гэнэтийн аваар саатал болон бусад шалтгаанаар төлөвлөгдөөгүй хийгдэх худалдан авалтыг судалж, шийдвэрлэх;

4.3.Хэрэгцээт сэлбэг, бараа материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэгтгэн тусгах;

4.5.Өмнөх жилүүдийн худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдсэн бараа материалын үнийн судалгааны сан бүрдүүлэх, гүйцэтгэл дээр үндэслэн бараа материалын үнийн прогноз гаргах;

